



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар

A/05

Модот

Мод бэлтгэл явуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 25 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 оны эхний хагас жилд сумын ойн сангаас ойн мэргэжлийн байгууллага иргэдийн ахуйн хэрэгцээнд арчилгаа цэвэрлэгээний огтлолт, цэвэрлэгээний ажил, уламжлалт бүтээгдэхүүнээр бэлтгэх модны хэмжээг хавсралтаар баталсугай.


2.Хуваарьт орсон ойн мэргэжлийн байгууллагууд арчилгаа цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэсэн модны 100м³ тутамд холбогдох аж ахуйн нэгж өөрийн хөрөнгөөр 1 га талбайд ойн, Уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар нас гүйцсэн ургаа нойтон мод ойгоос бэлтгэсэн иргэд огтолсон нэг модны оронд арав буюу түүнээс дээш тарьц суулгацыг ойд тарьж ойжуулалтын ажлыг чанартай зохион байгуулаж тарьж ургуулахыг ойн мэргэжлийн байгууллагуудад, хяналт тавьж ажиллахыг ойн ангийн дарга (П.Баярсайхан)-д үүрэг болгосугай.

3.Мод бэлтгэх эрхийн бичиг олголтонд болон мод бэлтгэл, тээвэрлэлт дээр байнгын хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч С.Энхбаяр, байгаль хамгаалагч Ж.Тодбилэг нарт тус тус хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ



2026 оны эхний хагас жилд арчилгаа цэвэрлэгээний огтлолт, цэвэрлэгээний ажил, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар бэлтгэх модны хэмжээ

Огтлолтын төрөл	Зориулалт	Модны төрөл	Хэмжих нэгж	Гансоёмбо ХХК	Буман ногоон төгөл ХХК	Мэргэн засаг ЗГБХН	Бэрх эрдэнэ ХХК	Баянмод баг	Хужхан баг	Согоот баг	Нугаар баг	Сумын хэмжээнд	Нийт бэлтгэх модны хэмжээ
Арчилгааны огтлолт	Хэрэглээ	МЗ		40	35	35	40						150
	Дүн		МЗ	40	35	35	40						150
	Түлээ	МЗ		25	25	25	25						100
	Дүн		МЗ	25	25	25	25						100
Бүгд			МЗ	65	60	60	65						250
Цэвэрлэгээний огтлолт	Хэрэглээ	Шинэс	м ³	190	190	185	185						750
	Дүн		м ³	190	190	185	185						750
	Түлээ	Шинэс	м ³	250	250	250	250						1000
	Дүн		м ³	250	250	250	250						1000
Бүгд				440	440	435	435						1750
Уламжлалт бүтээгдэхүүн	Хэрэглээ	Шинэс	м ³									50	50
	Дүн		м ³									50	50
	Түлээ	Шинэс	м ³									25	25
	Дүн		м ³									25	25
Бүгд			м ³									75	75
Цэвэрлэгээний ажил	Хэрэглээ	Шинэс	м ³					100	100	100	100		400
	Дүн		м ³					100	100	100	100		400
	Түлээ	Шинэс	м ³					375	375	375	375		1500
	Дүн		м ³					375	375	375	375		1500
Бүгд			м ³					475	475	475	475		1900
Нийт дүн			м ³	505	500	495	500	475	475	475	475	75	3975
Нийт хэрэглээ			МЗ	230	225	220	225	100	100	100	100	50	1350
Нийт түлээ			МЗ	275	275	275	275	375	375	375	375	25	2625

